

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/02-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a> Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>  Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>  Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:ankhbayaro@audit.gov.mn">ankhbayaro@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

БАРУУНБҮРЭН СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Ц.СЭЛЭНГЭ ТАНАА

2024.07.28 № 07А-2024/16-НА-СА-ТТЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон **18,541.8** мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасантай болон Сангийн сайдын Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”, 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”- тай тус тус нийцээгүй байна

### Асуудлыг онцолсон хэсэг

018020433

Сумын ИТХ-ын 2023 оны 10 дугаар сарын 20-ны “2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 104 дугаар тогтоолоор 658,594.1 мянган төгрөгийн татварын орлого, 20,000.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 668,004.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 1.6 хувиар тасалсан байна.

### **Аудитын гол асуудал**

ЗДТГ нь өөрийн үйл ажиллагааны орлого болох түрээсийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр хэт багаар буюу 500.0 мянган төгрөгөөр төлөвлөж батлуулсан бөгөөд гүйцэтгэлээр төлөвлөгөөнөөс давсан 8,383.5 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Баруунбүрэн сумын Засаг дарга нь тайлант онд 20 зорилт, 229 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 85.5 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## **АГУУЛГА**

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	10
3.4.2 Авлага .....	11
3.4.3 Бараа материал.....	11
3.4.4 Үндсэн хөрөнгө .....	12
3.4.5 Засгийн газрын хувь оролцоо .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.7.1 Завсрын аудитын талаар.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.1 Албан шаардлага .....	20
5.3 Зөвлөмж .....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	21

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХАА	Хөдөө аж ахуй
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон **18,541.8** мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасантай болон Сангийн сайдын Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан *“Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”*, 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан *“Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”*- тай тус тус нийцээгүй байна

### Асуудлыг онцолсон хэсэг

Сумын ИТХ-ын 2023 оны 10 дугаар сарын 20-ны “2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 104 дугаар тогтоолоор 658,594.1 мянган төгрөгийн татварын орлого, 20,000.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт

төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 668,004.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 1.6 хувиар тасалсан байна.

### **Аудитын гол асуудал**

ЗДТГ нь өөрийн үйл ажиллагааны орлого болох түрээсийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр хэт багаар буюу 500.0 мянган төгрөгөөр төлөвлөж батлуулсан бөгөөд гүйцэтгэлээр төлөвлөгөөнөөс давсан 8,383.5 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Баруунбүрэн сумын Засаг дарга нь тайлант онд 20 зорилт, 229 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 85.5 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,237,811.4</b>	<b>534,332.9</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	991,022.8	288,050.5
33	АВЛАГА	83,458.2	153,372.2
35	БАРАА МАТЕРИАЛ	163,330.3	92,910.3
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,218,011.6</b>	<b>4,009,308.0</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,218,011.6	4,009,308.0
39200	Биет хөрөнгө	2,193,664.4	3,985,860.8
39300	Биет бус хөрөнгө	24,347.2	23,447.2
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,455,823.0</b>	<b>4,543,640.9</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,455,823.0</b>	<b>4,543,640.9</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,455,823.0	4,543,640.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	278,919.3	278,919.3
51200	Хуримтлагдсан үр дүн	2,966,179.5	4,053,997.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	210,724.1	210,724.1
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,455,823.0</b>	<b>4,543,640.9</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,650,315.9</b>	<b>3,705,752.0</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	835,416.1	620,759.2
110	Орлогын албан татвар	184,376.1	279,282.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	184,376.1	310,432.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-31,150.3
113	Хөрөнгийн албан татвар	107,672.3	235,399.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	543,367.8	106,077.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	610,819.4	2,053,035.9
120	Нийтлэг татварын бус орлого	610,819.4	2,053,035.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,204,080.4	1,031,956.9
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,063,038.8</b>	<b>1,854,184.3</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,063,038.8	1,758,968.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,060,858.4	1,722,275.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	383,363.7	659,913.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,204.4	81,421.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	285,603.5	81,261.2
2104	Хангамж, бараа материалын зардал	61,163.4	78,252.9
2105	Нормативт зардал	826.6	490.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,835.1	20,397.2
2107	Томилолт, зочны зардал	9,074.6	11,727.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,164.0	413,340.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	231,623.1	375,471.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,002,180.3	36,692.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	95,215.7
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,587,277.1</b>	<b>1,851,567.7</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>9,500.0</b>	<b>0.0</b>

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,062,279.5	763,749.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,465,502.3	1,087,818.0

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,925,682.2	4,925,682.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,356.9	-4,356.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,921,325.3	4,921,325.3
9	Тайлант үеийн үр дүн	-1,465,502.3	-1,465,502.3
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,455,823.0	3,455,823.0
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,455,823.0	3,455,823.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,455,823.0	3,455,823.0
19	Тайлант үеийн үр дүн	1,087,818.0	1,087,818.0
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,543,640.9	4,543,640.9

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,216,839.8	1,814,304.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	835,416.1	620,759.2
110	Орлогын албан татвар	184,376.1	279,282.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	184,376.1	310,432.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-31,150.3
113	Хөрөнгийн албан татвар	107,672.3	235,399.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	543,367.8	106,077.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	23,827.5	10,341.1
1181	Газрын төлбөр	48,926.1	31,855.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	470,614.1	63,881.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,462.6	161,588.0
120	Нийтлэг татварын бус орлого	175,462.6	161,588.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,205,961.1	1,031,956.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,887,787.8	1,465,315.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,887,787.8	1,465,315.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	883,680.0	1,428,623.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	385,028.3	659,913.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,405.2	81,421.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	285,603.5	81,261.2
2104	Хангамж, бараа материалын зардал	53,339.1	61,530.9
2105	Нормативт зардал	1,724.5	1,307.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,810.1	29,287.2
2107	Томилолт, зочны зардал	9,074.6	11,727.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,472.7	413,494.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,222.0	88,679.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,004,107.8	36,692.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,329,052.0	348,988.4

V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>835,689.8</b>	<b>931,960.7</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>835,689.8</b>	<b>931,960.7</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	835,689.8	931,960.7
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-835,689.8</b>	<b>-931,960.7</b>
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>0.0</b>	<b>-120,000.0</b>
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>0.0</b>	<b>120,000.0</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>493,362.3</b>	<b>-702,972.3</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	497,660.6	991,022.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	991,022.8	288,050.5

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,839,879.0</b>	<b>2,415,907.3</b>	<b>-423,971.7</b>	<b>85.1</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,606,147.2</b>	<b>1,546,747.6</b>	<b>-59,399.6</b>	<b>96.3</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,561,210.2</b>	<b>1,511,604.8</b>	<b>-49,605.4</b>	<b>96.8</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	682,972.7	659,913.4	-23,059.3	96.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,315.6	81,421.1	-3,894.5	95.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	396,817.2	382,521.5	-14,295.7	96.4
2104	Хангамж, бараа материалын зардал	58,375.9	56,975.5	-1,400.4	97.6
2105	Нормативт зардал	977.5	977.5	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	215,185.5	214,175.5	-1,010.0	99.5
2107	Томилолт, зочны зардал	14,719.3	11,727.5	-2,991.8	79.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,019.9	17,562.0	-457.9	97.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,826.6	86,330.8	-2,495.8	97.2
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,937.0</b>	<b>35,142.8</b>	<b>-9,794.2</b>	<b>78.2</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,937.0	35,142.8	-9,794.2	78.2
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,047,489.2</b>	<b>749,159.7</b>	<b>-298,329.5</b>	<b>71.5</b>
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>186,242.6</b>	<b>120,000.0</b>	<b>-66,242.6</b>	<b>64.4</b>
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,839,879.0</b>	<b>2,381,320.7</b>	<b>-458,558.3</b>	<b>83.9</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	0.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,950,978.4	2,266,977.7	315,999.3	116.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	888,900.6	114,343.0	-774,557.6	12.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	200,580.6	200,580.6	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	165,993.9	165,993.9	
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>59.0</b>	<b>59.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.0	3.0	0.0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28.0	28.0	0.0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.0	28.0	0.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>101,369.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,384.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>7,834.10</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	4,555.40
2105	Нормативт зардал	330.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,348.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,550.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,550.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>91,985.00</b>
2200	Дотоод эх үүсвэр	91,985.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>101,369.10</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,369.10
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “*Эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлалд түшиглэсэн бизнес нь тогтвортой хөгжсөн, иргэдийн ажиллаж, амьдрах таатай орчин бүрдсэн хөгжлийн түвшингээрээ аймагтаа тэргүүлэх сумдын нэг болох*” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт

оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,

- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн зарим албан хаагчийн цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

2023 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баруунбүрэн сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”- ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,087,817.9 мянган төгрөгөөр буюу 31.5 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	991,022.8	288,050.5	-702,972.3
Авлага	83,458.3	153,372.1	69,913.8
Бараа материал	163,330.3	92,910.3	-70,420.0
Үндсэн хөрөнгө	2,218,011.6	4,009,308.0	1,791,296.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,455,823.0</b>	<b>4,543,640.9</b>	<b>1,087,817.9</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,455,823.0	4,543,640.9	1,087,817.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,455,823.0</b>	<b>4,543,640.9</b>	<b>1,087,817.9</b>

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсныг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 288,050.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 702,972.3 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	991,022.8	288,050.5	-702,972.3
Төгрөг	991,022.8	288,050.5	-702,972.3
Төрийн сангийн харилцах	991,022.8	288,050.5	-702,972.3

<b>Дүн</b>	<b>991,022.8</b>	<b>288,050.5</b>	<b>-702,972.3</b>
------------	------------------	------------------	-------------------

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд тайлагнагдсан Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 122,056.6 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 125,815.2 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 40,178.7 мянган төгрөг тус тус байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 153,372.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 69,913.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	0.0	0.0	0.0
Зээлийн хүүгийн авлага	3,242.1	344.0	-2,898.1
Байгууллагаас авах авлага	1,522.7	1,522.6	-0.1
Хувь хүмүүсээс авах авлага	4,066.7	123,796.7	119,730.0
Хувь хүмүүст олгосон зээл	74,626.8	27,708.8	-46,918.0
<b>Дүн</b>	<b>83,458.3</b>	<b>153,372.1</b>	<b>69,913.8</b>

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 4,066.7 мянган төгрөгийн итгэлийн зээлийн авлага байна.

Тайлант оны нийт авлагын үлдэгдлийн 96.4 хувь буюу 147,782.7 мянган төгрөгийг Хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэл эзэлж байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 92,910.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 70,420.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Тусгай зориулалттай материал	0.0	0.0	0.0
Эм боох материал	0.0	0.0	0.0
<b>Хангамжийн материал</b>	<b>163,330.3</b>	<b>92,910.3</b>	<b>-70,420.0</b>
Бичиг хэргийн материал	4,959.8	4,705.5	-254.3
Аж ахуйн материал	82,316.9	82,551.2	234.3
Сэлбэг хэрэгсэл	0.0	0.0	0.0
Түлш, шатах тослох материал	0.0	0.0	0.0
Хүнсний материал	0.0	0.0	0.0
Бусад хангамжийн материал	76,053.6	5,653.6	-70,400.0
<b>Мал амьтад</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>Дүн</b>	<b>163,330.3</b>	<b>92,910.3</b>	<b>-70,420.0</b>

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 70,420.0 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 742,842.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 117,760.4 мянган төгрөгийн бараа материал хүлээн авсан болон 924,877.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан, 6,145.2 мянган төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 4,009,308.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,791,296.4 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>2,193,664.4</b>	<b>3,985,860.8</b>	<b>1,792,196.4</b>
Барилга, байгууламж, орон сууц	1,050,301.1	2,063,281.3	1,012,980.2
Авто-тээврийн хэрэгсэл	70,674.2	41,998.0	-28,676.2
Машин тоног төхөөрөмж(компьютер)	105,650.7	121,878.7	16,228.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	49,616.9	141,251.2	91,634.3
Дуусаагүй барилга байгууламж	0.0	0.0	0.0
Номын фонд	55,347.2	55,217.2	-130.0
Бусад үндсэн хөрөнгө	862,074.3	1,562,234.4	700,160.1
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>24,347.2</b>	<b>23,447.2</b>	<b>-900.0</b>
Программ хангамж	1,454.2	554.2	-900.0
Бусад биет бус хөрөнгө	22,893.0	22,893.0	0.0
<b>Дүн</b>	<b>2,218,011.6</b>	<b>4,009,308.0</b>	<b>1,791,296.4</b>

*Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 1,791,296.4 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Сумын ОНХС, ОНХО-аас хийгдсэн 69,078.6 мянган төгрөгийн барилга байгууламж, 29,196.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 6,933.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил орлогод авсан,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 699,155.0 мянган төгрөгийн нутгийн удирдлагын ордон, 490,873.5 мянган төгрөгийн хүлэмж орлогод авсан,
- Аймгийн ОНХС, ОНХО-аар 3,016.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 236,685.0 мянган төгрөгийн барилга байгууламж орлогод авсан,
- Ойн ангиас 3,123.0 мянган төгрөг, ЗДТГ-аас 22,707.3 мянган төгрөг, Спорт цогцолбороос 1,600.3 мянган төгрөг зэрэг нийт 22,707.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил болон бусад үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

### 3.4.5 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,543,640.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,087,817.9 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 6. Засгийн газрын хувь оролцоо

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	278,919.3	278,919.3	0.0
Хуримтлагдсан үр дүн	2,966,179.6	4,053,997.5	1,087,817.9
Өмнөх үеийн үр дүн	4,431,681.9	2,966,179.5	-1,465,502.4
Тайлант үеийн үр дүн	-1,465,502.3	1,087,818.0	2,553,320.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	210,724.1	210,724.1	0.0
<b>Дүн</b>	<b>3,455,823.0</b>	<b>4,543,640.9</b>	<b>1,087,817.9</b>

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл урьд оноос 31.5 хувиар өссөн нь тайлант үеийн үр дүн 2,553,320.3 мянган төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Баруунбүрэн сумын ИТХ-ын 2023 оны 10 дугаар сарын 20-ны “2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 104 дугаар тогтоолоор 658,594.1 мянган төгрөгийн татварын орлого, 20,000.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 668,004.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 1.6 хувиар тасалсан байна.

### Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын орлого</b>	<b>658,594.1</b>	<b>620,759.2</b>	<b>-37,834.9</b>	<b>94.3</b>
Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	212,052.9	237,706.8	25,653.9	112.1
Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	33,000.0	29,397.2	-3,602.8	89.1
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	30,000.0	8,921.1	-21,078.9	29.7
Хөрөнгийн орлого	20,500.0	37,729.0	17,229.0	184.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-31,150.3	-31,150.3	0.0	100.0
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	5,500.0	5,599.8	99.8	101.8
Бууны албан татвар	540.0	990.0	450.0	183.3
Малд ногдуулах албан татвар	214,773.5	225,488.0	10,714.5	105.0
Улсын тэмдэгтийн хураамж	7,000.0	4,428.1	-2,571.9	63.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,100.0	4,193.5	3,093.5	381.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,000.0	1,719.5	-280.5	86.0
Газрын төлбөр	29,547.0	31,855.5	2,308.5	107.8
Газрын дуудлага худалдаа	21,439.0	0.0	-21,439.0	0.0

/мянган төгрөг/

Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр	96,117.0	59,173.3	-36,943.7	61.6
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	995.0	1,720.3	725.3	
Байгалийн ургамал ашигласны төлбөр	15,180.0	2,987.4	-12,192.6	19.7
<b>Татварын бус орлого</b>	<b>20,000.0</b>	<b>47,245.0</b>	<b>27,245.0</b>	<b>236.2</b>
Хүү, торгуулийн орлого	15,000.0	34,373.0	19,373.0	229.2
Бусад орлого	5,000.0	12,872.0	7,872.0	257.4
<b>Нийт дүн</b>	<b>678,594.1</b>	<b>668,004.2</b>	<b>-10,589.9</b>	<b>98.4</b>

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 25,653.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2023 оны 7 дугаар сараас төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалсан,
- Хөрөнгийн орлого 17,229.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд иргэдийн хадгаламж, хүүхдийн мөнгөний хадгаламж өссөнөөр тухайн орлого 84.0 хувь давж биелсэн,
- Малын тоо толгойн албан татвар 10,714.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд 2021,2022 оны өрийн үлдэгдлийг татварын нэхэмжлэл хүргүүлэн шат дараалсан арга хэмжээ авч ажилласантай холбоотой,
- Хүү торгуулийн орлого 19373,0 мянган төгрөгөөр, нэр заагдаагүй бусад орлого 7,872.0 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн нь тайлант онд Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэсэгтэй хамтран ажиллах болсон ба хууль бусаар самар бэлтгэсэн иргэдийг зөрчлийн хуулийн дагуу торгууль шийтгэл оногдуулсантай холбоотой болно.

Тасарсан орлогууд:

- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 21,078.9 мянган төгрөгөөр тасарсан нь сумын нутаг дэвсгэрт бүртгэлтэй иргэн, ААН байгууллагын үл хөдлөх хөрөнгө борлуулалт бага байснаас шалтгаалсан,
- Газрын дуудлага худалдаа 21,439.0 мянган төгрөгөөр буюу 100% тасарсан нь тайлант онд газрын даамалгүй ажилласан ба ИТХ-д газар зохион байгуулалтын төлөвлөгөө оруулан батлуулаагүйн улмаас тухайн төлбөр хураамжийн орлого тасарсан,
- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого нь 36,943.7 мянган төгрөгөөр тасарсан нь аймгийн ИТХ-аас Орхон бүсийн сумуудад хуваарилсан түлш болон хэрэглээний модны зөвшөөрөл буурсан, мод бэлтгэх мэргэжлийн байгууллагууд модоо бэлтгээгүйтэй холбоотой,
- Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого 12,912.6 мянган төгрөгөөр тасарсан нь тайлант онд самрын ургац муу байсантай холбоотойгоор суманд үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх самрын эрх олгогдоогүйтэй холбоотой байна.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 710,046.7 мянган төгрөгөөр, татварын болон татварын бус орлогоос 450,260.0 мянган төгрөгөөр, өөрийн үйл ажиллагааны орлогоос 7,500.0 мянган төгрөгөөр зэрэг нийт орлого, зарлагыг **1,167,806.7** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 78 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 671,691.5 мянган төгрөгөөр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 759,576.1 мянган төгрөгөөр, төсөвт газрын өөрийн орлогыг 43,325.0 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 354,904.9 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 763,575.6 мянган төгрөг, ХХС-ийн орлогоос 80,000.0 мянган төгрөг зэрэг нийт **2,675,073.1** мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 104 дүгээр тогтоолоор дараах өөрчлөлтийг оруулан төсвийн орлого, зарлагыг нэмэгдүүлж **2,839,879.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

Санхүүжүүлэх эх үүсвэрийн өөрчлөлт:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 6,902.6 мянган төгрөгөөр,
- Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 70,755.5 мянган төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 87,147.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Төсвийн зарлагын өөрчлөлт:

- ИТХ-ын урсгал зардлыг 7,626.1 мянган төгрөгөөр,
- ЗДТГ-ын урсгал зардлыг 72,478.4 мянган төгрөгөөр,
- ОНХС-ын зардлыг 87,147.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Ойн ангийн тогтмол зардлыг 2,446.4 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 830,331.6 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 442,052.7 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 763,575.6 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 80,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 678,594.1 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 45,325.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зэрэг нийт **2,839,879.0** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 488,535.1 мянган төгрөгийг аймгийн төсвийн санхүүгийн дэмжлэгээс, 442,052.7 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 763,575.6 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 668,004.2 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 64,256.9 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 50,086.1 мянган төгрөгийг ХХС-ын зээлийн эргэн төлөлтөөс зэрэг нийт **2,476,510.6** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,415,907.3** мянган төгрөг буюу **85.1** хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 23,059.3 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 14,295.7 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 9,794.2 мянган төгрөгөөр эргэж төлөгдөх зээлийн зардал 66,242.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 25 төсөл, арга хэмжээнд 832,360.6 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 575,815.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 125,815.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь албан татварын орлогын 45.5 хувь нь буюу 102,486.7 сая төгрөгийн орлого тайлант оны 4-р улиралд орсноор бүтээн байгуулалтын 12 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ-өөс 1,759.9 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчдаас 96,654.1 мянган төгрөг /ОНХО, ОНХС-аас эрх шилсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт 91,985.1 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас хамтарсан багийн санхүүжилт 300.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс ХАА-н тооллогын санхүүжилт 2,169.0 мянган төгрөг, нийтийн биеийн тамирын арга хэмжээний 1,600.0 мянган төгрөг, ГБХЗХГ-аас хүүхдийн чуулганы дэмжлэг 600.0 мянган төгрөг/, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,955.1 мянган төгрөг зэрэг нийт 101,369.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 9,985.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 91,985.0 мянган төгрөг зэрэг нийт 101,369.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Сумын ОНХО-ын төсвөөс 215,128.6 мянган төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ, ОНХС-ийн төсвөөс 832,360.6 мянган төгрөгийн 25 төсөл, арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна.

Гүйцэтгэлээр харьцуулалтын аргаар гүйцэтгэх 7 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс					
			Шууд худалдан авалт		Харьцуулалтын арга		Нээлттэй тендер шалгаруулалт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХО	2	95,000.0			2	95,000.0		
Сумын ОНХС	5	455,212.8			3	105,000.0	2	350,212.8
<b>Нийт</b>	<b>7</b>	<b>550,212.8</b>			<b>5</b>	<b>200,000.0</b>	<b>2</b>	<b>350,212.8</b>

Эх сурвалж: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруунбүрэн сумын ТТЗ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунбүрэн сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1,088,691.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **10,886.9** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,854,184.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **18,541.8** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

#### 4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баруунбүрэн сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Батлагдсан төсвийг 14.9 хувиар хэмнэсэн,
- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулаагүй,
- Албан хаагчдын гар утасны зардал гаргаагүй, сонин хэвлэл захиалаагүй,
- Үндэсний баяр наадмаас бусад баяр ёслол, ойн арга хэмжээнд төсвөөс хөрөнгө зарцуулаагүй,

#### 4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	183	142	41	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	183	172	11	
3	Засаг даргын Тамгын газар	183	179	4	
4	Орхон бүсийн сум дундын ойн анги	183	175	8	
	<b>Нийт дүн</b>	<b>732</b>	<b>668</b>	<b>64</b>	

Эх сурвалж: [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)

ТТЗ-ийн түвшинд нийт мэдээлбэл зохих 730 мэдээллээс 608 мэдээллийг хугацаанд нь, 64 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэлт: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж үзлээ.

## 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.7.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	450.0	1	450.0	100.0
Албан шаардлага	10	19,420.7	10	19,420.7	100.0
<b>Нийт дүн</b>	<b>11</b>	<b>19,870.7</b>	<b>11</b>	<b>19,870.7</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

## 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2023 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 58,385.5 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 1,015.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 34,615.7 мянган төгрөгийн албан шаардлага, 12,164.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

### 5.1 Төлбөрийн акт

1. ЗДТГ нь бараа үйлчилгээний зардлын батлагдсан төсвөөс 9 албан хаагчид **1,015.0** мянган төгрөгийн үнэ бүхий спорт хувцас, өмсгөл, малгай, футболк зэргийг худалдан авсан байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## **5.1 Албан шаардлага**

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар, хөтөлбөр, зориулалт, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй **34,615.7** мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

### **ИТХ:**

- Бараа үйлчилгээний бусад зардлаас бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлсийн зардалд /*ус буцалгагч, усны суурь, чихрийн таваг... г.м/* 684.0 мянган төгрөг,

### **ЗДТГ:**

- Бараа үйлчилгээний бусад зардлаас тээвэр, шатахууны зардалд 194.7 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардалд /*халуун сав, сандал, аяга таваг.. г.м/* 3,328.0 мянган төгрөг, хоол, хүнсний зардалд /*ундаа, ус, хуушуур, набор, усан үзэм, чихэр, гахайн мах.. г.м/* 10,510.8 мянган төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардалд /*хөшиг, орны даавуу, гудас, хөнжил... г.м/* 5,985.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд /*автомашинны сэлбэг, труба, хард диск.. г.м/* 7,129.3 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардалд 600.0 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас хоол, хүнсний зардалд 1,860.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,061.5 мянган төгрөг,
- Багаж техник, хэрэгслийн зардлаас урсгал засварын зардалд 1,357.4 мянган төгрөг,

### **ЗДНХ:**

- Гадаад томилолтын зардалд 1,905.0 мянган төгрөг,

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтууд болон Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “*Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал*”, 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай бол төсөвт зохицуулалт хийлгэх албан шаардлага хүргүүлэх.

2. Орон нутгийн төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөөг **10,589.9** мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн “... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална.”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

#### 1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: ЗДТГ нь өмч хамгаалах зөвлөлөөр автомашинд засвар, үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх техникийн комиссын дүгнэлт, акт зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр засвар үйлчилгээнд нийт 12,164.9 мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл, тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр, техникийн комиссын акт, дүгнэлтийг үндэслэн авто машины засвар үйлчилгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ТТЗ	4	58,385.5	1	1,015.0	2	45,205.6	1	12,164.9				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>58,385.5</b>	<b>1</b>	<b>1,015.0</b>	<b>2</b>	<b>45,205.6</b>	<b>1</b>	<b>12,164.9</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
64 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1				1			
<b>Дүн</b>	<b>1</b>				<b>1</b>			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>				<b>1</b>			